



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А28

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөрийн 2.1.9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.ХБНГУ-ын Хессен мужтай хамтын ажиллагааг эхлүүлсэнтэй холбоотойгоор тус улсад Монгол Улсаас суугаа элчин сайдын яам, мужийн захиргаанд цагаан сарын арга хэмжээний зардалд 415 000 (дөрвөн зуун арван таван мянга) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх 415 000 (дөрвөн зуун арван таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100073